

**2019 ОНЫ 3 ДУГААР САРЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/427 тушаалын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл бүртгэгдсэн 7 байгууллага /УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, НЭМГ/ мэдээ ирүүлсэн.

**Нэг. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн амбулаторийн үзлэгийн хүлээгдэл:**

2019 оны 3 дугаар сард УНТЭ, УГТЭ, СЭМҮТ, ЭХЭМҮТ амбулаторийн хүлээгдэлгүй байна. УХТЭ 92, ХСҮТ 391 хүлээгдэл бүртгэгдсэн байна.

УХТЭ-т нийт 7 кабинетэд 92 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Үүнд:

- Бөөр судлалын кабинет 36
- Зүрх судасны кабинет 40
- Уушигны кабинет 6
- Мэдрэл судлалын кабинет 1
- Нүдний кабинет 3
- Урологийн кабинет 2
- Уламжлалтын кабинет 45
- Эмэгтэйчүүдийн кабинет 4 үйлчлүүлэгч тус тус 2-3 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.


ХСҮТ-ийн амбулаторийн 11 кабинетэд нийт 391 үйлчлүүлэгч үйлчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнд:

- Зүрх судасны кабинет 30
- Мэс засал 20
- Элэг цөс нойр булчирхайн кабинет 66
- Толгой хүзүүний мэс заслын кабинет 42
- Эмэгтэйчүүдийн мэс заслын кабинет 63
- Цээжний хөндийн мэс заслын кабинет 42
- Гепатологийн кабинет 32
- Хөнгөвчлөх 3
- Туяа эмчилгээний кабинет 19
- Хими эмчилгээний кабинет 35
- Ангиографийн кабинет 39 үйлчлүүлэгч тус бүр 1-7 ба түүнээс дээш хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ. Өдөртөө үйлчлүүлсэн 79 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

УХТЭ-ийн 2019 оны 3-р сарын амбулаторийн хүлээгдлийг үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



ХСҮТ-ийн 3-р сарын амбулаторийн хүлээгдлийг үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



**Хоёр. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн оношлогооны кабинетийн хүлээгдэл:**

2019 оны 3 дугаар сард УХТЭ, УГТЭ, ХСҮТ-ийн оношлогооны тасгуудад хүлээгдэл бүртгэгдсэн байна.

УХТЭ-т оношлуулахаар 72 үйлчлүүлэгч 2-15 түүнээс дээш хоног хүлээгдэлтэй байна. Үүнд:

- Рентген зураг 23
- Зүрхний цахилгаан бичлэг 20

- Хэвлийн эхо 15
- Ходоодны дуран 14 үйлчлүүлэгч оношлуулахаар 2-14 түүнээс дээш хоног тус тус хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 204 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т оношлуулахаар 39 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

Үүнд:

- Рентген зураг 20
- Хэвлийн эхо 11
- Тархины цахилгаан бичлэг 4
- Допплерографи 4 үйлчлүүлэгч тус бүр 1-2 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 126 үйлчлүүлэгч байна.

ХСҮТ-д анх удаа оношлуулахаар дугаар авсан 166 үйлчлүүлэгчээс өдөртөө үйлчлүүлсэн 33 үйлчлүүлэгч, 7 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй 147, 2-6 хоногийн хүлээгдэлтэй 19 үйлчлүүлэгч байна.

Үүнд: Бүдүүн шулуун гэдэсний дуран 3 үйлчлүүлэгч, уушигны дуран 2, ходоодны дуран 31, хэвлийн ЭХО 79, зүрхний цахилгаан бичлэг 31, рентген харалт 20 үйлчлүүлэгч тус бүр 2-14 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ.

Өдөртөө үйлчлүүлсэн 33 үйлчлүүлэгч байна.

УНТЭ, ЭХЭМҮТ, СЭМҮТ-д оношилгооны хүлээгдэлгүй байна.

УХТЭ, УГТЭ, ХСҮТ-ийн оношлогооны кабинетийн 3-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



### Гурав. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн лабораторийн шинжилгээний хүлээгдэл:

2019 оны 3 дугаар сард УНТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ эмнэлгүүд лабораторийн шинжилгээний хүлээгдэлгүй.

УХТЭ, УГТЭ-т лабораторийн шинжилгээний хүлээгдлийг бүртгэн мэдээлсэн.

УХТЭ-т лабораторийн нийт хүлээгдэл 437 үйлчлүүлэгч 2-6 хоногийн хүлээгдэлтэй байна. Үүнд: Цусны ерөнхий шинжилгээ 22, шээсний ерөнхий шинжилгээ 17, биохими 342, бактериологийн шинжилгээ 34, иммунологийн шинжилгээ 8, сериологийн шинжилгээ 4, коагулограммын шинжилгээ 10 үйлчлүүлэгч 2-6 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

Өдөртөө үйлчлүүлсэн 357 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т лабораторийн нийт хүлээгдэл 200 үйлчлүүлэгч 1-2 хоногийн хүлээгдэлтэй байна. Үүнд: Цусны ерөнхий шинжилгээ 89, шээсний шинжилгээ 39, биохимийн шинжилгээ 101, бактериологийн шинжилгээ 23 үйлчлүүлэгч 2-6 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

Шээсний ерөнхий шинжилгээ серологи, цитологи, иммунологи коагулограммын шинжилгээнүүд хүлээгдэлгүй.

Өдөртөө үйлчлүүлсэн 284 үйлчлүүлэгч байна.

УХТЭ, УГТЭ-ийн лабораторийн кабинетийн 2019 оны 3-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



### Дөрөв. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

2019 оны 3 дугаар сард хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг УХТЭ, УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ, ЭХЭМҮТ бүртгэн мэдээлсэн. УНТЭ-ийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэлгүй байна.

УХТЭ-т 3-р сард нийт 292 үйлчлүүлэгч 3 хоногоос 30 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна. Үүнд: Бөөрний тасагт 12, зүрх судасны системийн тасаг 20, уушигны тасагт 23, мэс заслын тасагт 140, мэдрэлийн тасагт 35, уламжлалт эмчилгээний тасагт 35, хоол боловсруулах эрхтэн системийн тасагт 27 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т 3-р сард нийт 275 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнээс: Бөөрний тасагт 6, уушигны тасагт 6, мэс заслын тасагт 16, мэдрэлийн тасагт 11, нүдний тасагт 5, хоол боловсруулах эрхтэн системийн тасагт 5, чих хамар хоолойн тасагт 152, мэдрэлийн мэс засалд 79 үйлчлүүлэгч тус тус 3-30 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.

ХСҮТ-д 3-р сард нийт 236 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнд 3-6 хоногийн хүлээгдэлтэй 71 үйлчлүүлэгч, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 101 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 41 үйлчлүүлэгч, 1 сараас дээш хүлээгдэлтэй 21 үйлчлүүлэгч байна.

ХСҮТ нь яаралтай тусламжаар өдөрт дунджаар 10 өвчтөн ирдэг, нийт ирж буй үйлчлүүлэгчдийн 98% нь хорт хавдрын хожуу шатандаа орсон өвчтөнүүд байдаг ба үүнээс хэвтэх шаардлагатай өвчтөнүүдийг хөнгөвчлөх болон бусад мэс заслын тасгуудад хэвтүүлдэг учир орны зөрүүтэй байдал үүсдэг.


Химийн тасгаар өвчтөн 14-21 хоногийн давтамжтай “товлолт” эмчилгээнд хамрагддаг тул хүлээгдэлтэй харагдаж байна.

Ангиографийн тасаг нь өдөрт дунджаар 10 өвчтөнд ажилбар хийдэг ба тус тасгийн дундаж ор хоног 1.6 тул ажилбар хийлгэхээр хүлээж буй өвчтөний тоо их байна.

СЭМҮТ-ийн стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 47 үйлчлүүлэгч 3-6 хоног, 42 үйлчлүүлэгч 7-14 хоног, 24 үйлчлүүлэгч 15-30 хоногийн хугацаанд нийт 113 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна.

ЭХЭМҮТ-ийн эмэгтэйчүүдийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 3-6 хоногийн хугацаанд 1 үйлчлүүлэгч хүлээж үйлчлүүлсэн.

СЭМҮТ-ийн неврозын тасгийн хүлээгдэл:



**Тав. НЭМГ-ын харьяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:**

НЭМГ-ын харьяа 8 эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэл бүртгэгдсэн байна. Эдгээрээс хамгийн олон хоногийн хүлээгдэл Сонгинохайрхан дүүргийн дотор 135, мэдрэл 55, Хан уул дүүргийн эрүүл мэндийн төвийн дотор 59, мэдрэл 31, БГДЭМТ-ийн дотор 52, мэдрэл 74, БЗДНЭ-ийн дотор 233, ахмадын эмнэлэг 144 үйлчлүүлэгч тус бүр 3-30 хоногийн хүлээгдэлтэй үйлчилсэн байна.

Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2019 оны 3-р сарын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг хүснэгтээр харуулав.


№	Үзлэгийн кабинетын нэр	Үзүүлэлт	3 сар										
			СХД ЭМТ	ХУД ЭМТ	ЧД ЭМТ	НД ЭМТ	БН ЭМТ	БГД ЭМТ	БЗД НЭ	СБД НЭ	ХУД НЭ	СХД НЭ	Наркологийн
1	Мэдрэл	Ор хүлээж байгаа өвчтний тоо	55	31	0	16	14	74	0	0	0	0	0
		1-3 хоног	9	16		4							
		3-6 хоног	34	14		8	8	2					
		7-14хоног	21	17		6	6	60					
		15-30 хоног				2		12					
		1 сараас дээш											
2	Дотор	Ор хүлээж байгаа өвчтний тоо	135	59	21	39	12	52	233	0	0	0	0
		1-3 хоног	5	19	36	13			35				
		3-6 хоног		20	16	17	10	7	68				
		7-14хоног	33	32	5	15	2	45	100				
		15-30 хоног	102	7		7			55				
		1 сараас дээш						10					
3	Ахмадын эмнэлэг	Ор хүлээж байгаа өвчтний тоо	144	0	0	0	0	10	0	0	0	0	0
		1-3 хоног	18					12					
		3-6 хоног	36					10					
		7-14хоног	54										
		15-30 хоног	54										
		1 сараас дээш											
4	Уламжлалт	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
		1-3 хоног											
		3-6 хоног											
		7-14хоног											
		15-30 хоног											

		1 сараас дээш												
5	Хавдар	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
		1-3 хоног												
		3-6 хоног												
		7-14хоног												
		15-30 хоног												
		1 сараас дээш												
6	Наркологийн тусламж үйлчилгээ	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	78
		1-3 хоног												27
		3-6 хоног												52
		7-14хоног												21
		15-30 хоног												5
		1 сараас дээш												


Нийслэлийн түргэн тусламжийн төвд 3 дугаар сард 27744 дуудлага бүртгэгдсэний 37.6%-ийг 0-20 минутад, 34.8%-ийг 21-40 минутад, 15.7%-ийг 41-60 минутад, 11.9 %-ийг 1 цагаас дээш хугацаанд хүрч үйлчилсэн байна.

Түргэн тусламжийн төвийн 3 дугаар сарын тусламж үйлчилгээний хүлээгдлийг өмнөх сартай харьцуулахад 1 цагаас дээш хугацаанд очсон дуудлага 5.3%-иар буурсан, хамгийн бага хугацаанд \0-20 минут\ хүрч үйлчилсэн тохиолдол 5.3%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 2019 оны 1-3 саруудад ирсэн дуудлагын тоо /хүрч үйлчилсэн хугацаагаар/



Нийслэлийн түргэн тусламжийн төвд  
сүүлийн 6 сарын хугацаанд ирсэн нийт дуудлагын тоо:



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ЛИЦЕНЗИЙН АЛБА